



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/425

Есөнбулаг

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит 2 байгууллагын хоёр барилга, байгууламжийг газар эзэмших эрхийн хамт, 11 байгууллагын 12 нэр төрлийн тээврийн хэрэгслүүдийг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Өмчийн төлөөлөгч:	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
Хөтлөгч:	Б.Золзаяа	(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
Тэмдэглэл хөтлөгч:	Ч.Лхагвадулам	(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
Гишүүн:	Х.Лхагважав	(Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	Ц.Баярсайхан	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн)

2.Нээлттэй дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (Ж.Билэгсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

